

# ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН “СҮЛД” ЧУУЛГА

2023 оны 12 дугаар  
сарын 04

Улаанбаатар  
хот

## “СҮЛД” ЧУУЛГЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн зорилт, шалгуур үзүүлэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” Цагдаагийн Ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны А/01 дүгээр тушаалаар баталсан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн зорилт, шалгуур үзүүлэлт, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан Сүлд чуулгын 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 29 заалттайгаар боловсруулан ЦЕГ-ын ЗУГ-ын даргаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Уран сайхны зөвлөл Сүлд чуулгаас 2023 онд хийж гүйцэтгэх уран бүтээлийн календарчилсан төлөвлөгөө, тус чуулгаас 2023 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалтыг гарган чуулгын даргаар батлуулан ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн харилцааг зохицуулахдаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн баримтжуулах зорилгоор удирдлага зохион байгуулалтын А-09, хүний нөөцийн чиглэлээр Б-86, нийт 95 тушаал гаргаж, тус чуулгын үйл ажиллагаа, алба хаагчдын сахилга ёс зүй, ажлын хариуцлага, үүрэг гүйцэтгэлтэй холбоотой, цаг үеийн шинжтэй даргаас 45 удаагийн 965 үүрэг, ажлын чиглэл өгч, хэрэгжилт, үр дүнг тооцон ажилласан.

2023 оны эхний 11 сарын байдлаар чуулгын даргын зөвлөлийн хурлыг 12 удаа зохион байгуулж удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр 15, хүний нөөцийн чиглэлээр 48 асуудлыг хэлэлцэж, гарсан шийдвэрийг тухай бүр алба хаагчдад мэдээлж ажиллав.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан загварын дагуу зохион байгуулалтын нэгжийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, мөн тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан загварын дагуу албан тушаалын тодорхойлолттой уялдуулан нийт 60 алба хаагч /14 офицер, 46 ахлагч/ төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Хоёр. Дээд шатны байгууллага, албан тушаалтнаас  
өгсөн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, албан  
даалгаврыг хэрэгжүүлэх талаар

Тайлант хугацаанд шинээр баталсан, нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомж, төрийн болон байгууллагын бодлого чиглэл, үйл ажиллагаатай холбоотой шийдвэр, удирдах байгууллагаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл, чуулгын болон алба хаагчдын үйл ажиллагаа, цаг үеийн нөхцөл байдал, бодлогын баримт бичиг тусгагдсан болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах, мэдээлэл хүргэхтэй холбоотойгоор Цагдаагийн ерөнхий газрын удирдлага, алба, нэгжээс эхний 9 сарын байдлаар ирүүлсэн нийт 68 удаагийн мэдээллийг давхардсан тоогоор 985 алба хаагчид мэдээлж, хэрэгжилтийг хангаж ажилласан.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, алба хаагчдад тулгамдаж буй асуудлын талаарх санал сэтгэгдлийг авах, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор үүсгэсэн “Алба хаагчдын чөлөөт индэр” цахим хаалттай бүлэгт чуулгын алба хаагчид бүрэн нэгдэж, 28 удаагийн шууд дамжуулалтад хамрагдан санал бодлоо илэрхийлсэн.

Ажлын өдрүүдэд ерөнхий эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй офицер алба хаагч нар рапортын дэвтэрт 1-2 санал бичиж байхыг чуулгын даргаас үүрэг болгосон, 2023 оны 11 сарын байдлаар давхардсан тоогоор нийт 156 алба хаагчаас 365 санал гарч, түүний дагуу холбогдох албан тушаалтанд даргаас хугацаатай үүрэг, чиглэл өгч хэрэгжилтийг хангаж ажилласан нь алба хаагчдын оролцоог хангаж, идэвх санаачилгыг нэмэгдүүлэхээс гадна чуулгын хэмжээнд тулгамдаж буй

асуудлыг олж харах, шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлж байгууллагын соёлыг дээшлүүлэхэд нөлөөлж байна.

Гурав. Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн талаар

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/53 дугаар "Сүлд чуулгын албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэх батлах тухай" тушаалын хүрээнд /офицер 16, ахлагч 46, энгийн 11/ нийт 73 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр батлагдсан боловч 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 67 /офицер-1, цагдаа-4, энгийн-1 орон тоо дутуу/ алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.

Тус чуулгын орон тооны нөхөн хангалтыг хийх зорилгоор төрийн албаны нөөцөд байсан 1 иргэнийг судалж бүжигчний албан тушаалын орон тоонд чуулгын даргын тушаалаар томилгоожуулж, хүний нөөцийн бодлогыг ил тод байлгах зорилгоор бусад сул орон тооны зарыг [www.unegui.mn](http://www.unegui.mn), "Цагдаагийн СҮЛД чуулга" фэйсбүүк пэйж хаяг, [www.suld.police.gov.mn](http://www.suld.police.gov.mn) албан ёсны хаягт байршуулж, ажиллах хүсэлт гаргасан 17 иргэнээс сонгон шалгаруулалтыг дотооддоо зохион байгуулж, шалгарсан хөгжимчин 2, бүжигчин 3, нярав 1, бүжгийн багш 1 нийт 9 иргэнийг Төрийн албаны салбар зөвлөлийн "Цагдаа" мэргэжил олгох сонгон шалгаруулалтад оролцуулж, нөөцөд бүртгүүлж, Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургуулийн "Цагдаа" мэргэжил олгох сургалтад хамруулж, томилуулах саналыг холбогдох газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн.

2023 онд шинээр томилогдсон 10 алба хаагчид чуулгын даргын тушаалаар халамжлан сургах багшийг томилж, ажлын байранд богино хугацаанд дасан зохицох хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан "Алба хаах" болон "Итгэлцлийн" гэрээг байгуулж ажилласан.

Алба хаагчдаас албан тушаал дэвшүүлэх тохиолдолд чадахуйн зарчим /мерит/-ын зорилтыг хангаж 2022 оны албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгэгдсэн 3 алба хаагчийг албан тушаал дэвшүүлэн томилуулсан.

Чуулгын алба хаагчдын цалингийн зэрэглэл, тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл, онцгой нөхцөлийн нэмэгдэл, орон тооны дэлгэрэнгүй судалгаа, шагнал, цол, ажилласан жилийн судалгаа, цахим хаягийн бүртгэл, алба хаагчдын утас, регистрийн, гэрийн хаягийн бүртгэл, 2023-2024 онд тэтгэвэрт гарах алба хаагчдын судалгаа, ахмад ажилтны судалгаа, хүүхдийн судалгааг гаргаж, 2022 онд тус чуулгаас гарсан нийт 10, энэ 3 дугаар улирлын байдлаар гарсан 9 иргэний материалыг "Архив ,албан хэрэг хөтлөлтийн тухай хууль", "Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам", Байгууллагын архивын ажлын үндсэн зааварт заасны дагуу бүртгэн, тус бүрийг товьёогжуулж 32 ширхэг хадгаламжийн нэгж үүсгэн бичиг хэргийн эрхлэгч, архивчид хүлээлгэн өгсөн.

2023 оны 11 дүгээр сарын байдлаар чуулгаас Төрийн одон медалиар 7 алба хаагч, Цагдаагийн Ерөнхий газрын шагналаар 8 алба хаагч, Монгол улсын Соёлын яамны шгналаар 4 алба хаагч, Хууль зүйн яамны шагналаар 3 алба хаагчийг тус тус шагнуулсан.

Шинээр цагдаа албан тушаалд томилогдсон 7, албан тушаал өөрчилсөн 3, албан тушаал дэвшсэн 3 алба хаагчид албаны А серийн үнэмлэх, энгэрийн тэмдэг олгуулж, албанаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 4, албанаас халагдсан 1 алба хаагчдад тооцооны хуудас олгож, орсон, гарсан хөдөлгөөнийг тухай бүр хүний нөөцийн цахим санд оруулж архивын нэгж болгон хадгалсан байна.

Алба хаагчдын ажилласан жилийг тооцон цалингийн сүлжээ шатлалын дагуу тухай бүрд нь тогтоож баталгаажуулан хэвшсэн бөгөөд 2023 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 14 алба хаагч, 13 ажилтны цалингийн шатлал, төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг тооцон удирдлагад танилцуулан баталгаажуулж, Цагдаагийн байгууллагын нэгдсэн сүлжээ [/system.police.gov/-](http://system.police.gov/)нд байрлах хүний нөөцийн цахим санд мэдээллийг шинэчилсэн.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/340 дүгээр тушаалаар баталсан "Цалингийн зэрэглэл батлах тухай" тушаалын дагуу чуулгын цэргийн орон тоонд ажилладаг нийт 52 алба хаагчийн цалингийн зэрэглэлийг шинээр тогтоож, хүний нөцийн мэдээллийн санд шивж оруулан, чуулгын даргын тушаал гаргасан.

Мөн "Төрийн албаны тухай хууль"-ийн 60 дугаар зүйлийн 60.1-д заасны дагуу цэргийн алба хаасны байнгын тэтгэвэрт гарсан 3 ахмад ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж олгож өгөх

хүсэлтийг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба, Хүний нөөцийн хэлтэст хүргүүлж, 3 ахмад ажилтны 36 сарын тэтгэмжийг бүрэн олгуулсан.

Дөрөв. Өргөдөл, гомдол хүлээн авах,  
шийдвэрлэлтийн талаар

Цагдаагийн байгууллагын албан ёсны /[servise.police.gov.mn/](http://servise.police.gov.mn/) цахим хуудсаар иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэл байгаа эсэхэд хяналт тавих, иргэдийг ялгаварлан гадуурхахгүй, ижил тэгш, зөв шударга харьцаж, төрийн байгууллагад иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулах чиглэлээр 2023 онд иргэд байгууллага, алба хаагчдаас нийт 61 өргөдөл ирүүлснээс ажилд орох, суралцахыг хүссэн 18, ажилд дахин орохыг хүссэн 8, ажил өөрчлөх, шилжихийг хүссэн 3, захиргааны чөлөө хүссэн 11, бусад 11 асуудлаар хандсан ба үүнээс 61 өргөдлийг бүрэн шийдвэрлэж сар бүр мэдээг нэгтгэж Цагдаагийн ерөнхий газрын Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хүргүүлсэн.

Тав. Архив, албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн талаар

Албан хэрэг хөтлөлтийн журам, зааврын дагуу хөтлөгдвөл зохих бүртгэлийн “Ирүүлсэн албан бичиг /хариутай, хариугүй/, “Явуулсан албан бичиг”, “Удирдах дээд шатны байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн танилцуулга”, “Удирдах дээд шатны байгууллагаас ирүүлсэн албан бичиг”, “Өргөдөл гомдлын бүртгэлийн дэвтэр”, “Тушаалын бүртгэлийн дэвтэр” зэрэг 7 дэвтрийг хөтлөн чуулгын үйл ажиллагаанд өдөр тутам үүсч, хөтлөгдөж буй баримт бичгийн стандарт, зөв бичих дүрэм, Монгол хэлний найруулга зүйн алдаагүй боловсруулахад анхаарч, төслийг удирдах ажилтанд хянуулан, гарын үсгээр баталгаажуулсны дараа хэвлэмэл хуудсанд хэвлэж хэвшсэн.

“Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн үлсын үзлэг”- т бэлтгэх ажлын хэсгийг чуулгын даргын тушаалаар байгуулж, хийх ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд чуулгын даргаас 2023 оны 08 дугаар сарын 24-ны өдөр өгсөн чуулгын архивын үйл ажиллагаатай холбоотой 27 төрлийн үүргийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

1.Архивын өрөөнд бүрэн засвар /хана, тааз, шал будаж/ хийж, архивын баримт хадгалагдаж буй нягтаршуулсан тавцанг шинэчлэн засварлан, архивын стандартад нийцүүлэн ажиллаж байна.

2.Мөн 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийг тусгай төмөр сейфинд тус тусад нь байрлуулж архивын өрөөнд стандартын дагуу техник хэрэгслийг байршуулсан Тухайлбал: галын аюулгүй байдлын самбар, мэдээллийн самбар, галын аюулгүй байдлын дүгнэлт гэрчилгээ, хар өнгийн хөшиг, галын хор 2, элс, хүрз, чийгшил хэмжигч, термометр, дулаан хэмжигч, ус тус тус байрлуулсан.

3.Цагдаагийн ерөнхий газрын төв архивын дэргэдэх баримт нягтлан шалгах арга зүйн комиссын 11 дүгээр сарын 16-ны өдрийн 3 дугаар хуралдаанаар чуулгын 2022 оны баримтын бүртгэл болон байнга хадгалагдах 12 /2680 хуудас/, түр хадгалах 20 /5250 хуудас/, 70 жил хадгалах боловсон хүчний-1 /167 хуудас/, Санхүүгийн 70 жил хадгалах-3 /750 хуудас/,устгах хэргийн жагсаалт-228 /26866 хуудас/ баримтуудыг хурлаар оруулан батлуулан ажиллаж байна.

Мөн цахим архив үүсгэх үйл ажиллагаатай холбогдуулан Ньюсоник ХХК-тэй гэрээ байгуулан 880,000 төгрөгний цахим архивын сан үүсгүүлэн захирамжлалын баримт бичгээ оруулан ажиллаж байна.

Хадгаламжийн сангийн халаалт, агаар сэлгэлтийн системийн ажиллагаа, цахилгааны шугамын галын аюулгүй байдалд 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн Онцгой байдлын ерөнхий газраас №0003306 дугаартай Галын аюулгүй байдлын дүгнэлт хийлгэсэн.

Зургаа. Сахилга хариуцлага, ёс зүйг сайжруулах чиглэлээр

Алба хаагчдыг гэмт хэрэг, зөрчил, сахилга, ёс зүйн үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр алба хаагчдын идэвхи санаачилга, оролцоонд суурилсан сургалт, соён гэгээрүүлэх, шинэлэг арга хэлбэрийг ашиглан багийн үйл ажиллагаа, орон тооны бус ажлын хэсгүүдийг идэвхжүүлсэн ажил, арга хэмжээ зохион байгуулж, гэмт хэрэг зөрчил, сахилга, ёс зүйн зөрчлийг

бууруулах зорилгоор “Гэмт хэрэг, сахилга ёс зүйн зөрчилгүй хамт олон болохын төлөө” болзолт уралдааны хүрээнд дараах ажил, арга хэмжээг зохион байгууллаа.

2023 оны нэгдүгээр улиралд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дунд зохион байгуулагдсан “Удирдах ажилтны сургалт зөвлөгөөн”-д тус чуулгын дарга, захиргааны удирдлагын тасгийн дарга нар хамрагдан ажилласан.

Тус чуулгаас Цагдаагийн байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн зорилт, удирдах дээд шатны байгууллагаас ирүүлсэн үүрэг, албан даалгаврыг байгууллагын онцлогийн хүрээнд биелүүлж ажилласан бөгөөд тайлант хугацаанд 2 алба хаагчид албаны шалгалт хийж ажилласан.

2022 оны эхний 11 сарын байдлаар нийт 5 сахилгын зөрчилд 6 алба хаагч сахилгын арга хэмжээ авагдсан нь нийт бие бүрэлдэхүүний 9.3 хувийг эзэлж байсан. 2023 оны эхний 11 сарын байдлаар нийт 4 сахилгын зөрчилд, 3 алба хаагчид сахилгын шийтгэл ногдуулж, 1 алба хаагчийг албанаас халсан нь нийт бие бүрэлдэхүүний 5.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Сахилга, ёс зүйн зөрчил гаргасан 4 алба хаагчийн 3 нь ахлагч бүрэлдэхүүн, 1 нь энгийн ажилтан байна.

Мөн 7 хоног бүрийн Даваа, Баасан гарагуудын өглөөний нэгдэлт дээр алба хаагчдад албаны бэлэн байдал хангуулах, сахилга хариуцлага дээшлүүлэх, авлига ашиг сонирхлоос ангид байх, албаны дүрэмт хувцсыг цэвэр цэмцгэр өмсөж хэрэглэх, албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлэх, барилга байгууламжийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 45 удаагийн нийт 965 заалттай үүрэг, ажлын чиглэл өгч 953 үүрэг биелж, 96 хувь нь биелэгдсэн байна.

Долоо. Албаны сургалт,  
сургалт, соён гэгээрүүлэх ажлын талаар

**Албаны сургалтын чиглэлээр:** Тус чуулга нь Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2023 оны А/46 дугаар тушаалаар баталсан “Албаны болон давтан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-ний дагуу 2023 онд 79 удаагийн 119 цагийн сургалтад давхардсан тоогоор 4883 алба хаагч хамрагдаж, мэдвэл зохих хууль тогтоомжийн 40 удаагийн сургалтад давхардсан тоогоор 2477 алба хаагч, алба хаагчийг хөгжүүлэх 24 удаагийн сургалтад 1484 алба хаагч, дадлагажуулах 4 удаагийн сургалтад 245, бие бялдрын бэлтгэлжилтийн 11 удаагийн сургалтад 677 алба хаагч давхардсан тоогоор тус тус хамрагдаж, танхимын сургалт 9, дадлагын сургалт 13, зайн болон цахим сургалт 57 удаа зохион байгуулсан байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны А/73 дугаар тушаалаар зохион байгуулагдсан сургалт хариуцсан алба хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх 2 өдрийн сургалт, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын дунд зохион байгуулагдах “Бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэг”-ийн дүнг нэгтгэх программ, сургалтын Gosmart динамик системд ажиллах арга зүйн сургалтад соён гэгээрүүлэх, албаны сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн хамрагдсан.

Цагдаагийн ерөнхий газрын Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс, Хуулийн хэлтэс, ЦДЦСНТ-өөс Gosmart динамик системд зохион байгуулсан 7 удаагийн сургалт, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх алба хаагчдын мэдлэгийг шалгах шалгалт, ахлах албан тушаалтны болон алба хаагчдын хууль эрх зүйн шалгалтуудад тухай бүр хамрагдаж ирэв.

Алба хаагчдын илтгэх ур чадварыг дээшлүүлэх, зорилгоор чуулгын нийт алба хаагч, ажилтнууд 3-5 минутын хугацаанд нийт бие бүрэлдэхүүнд мэдээлэл хийх хуваарийг баталж, хэрэгжүүлж байна. Мэдээллийг нийт 73 алба хаагч хийж, давхардсан тоогоор 4080 алба хаагч хамрагдсан байна.

“Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох үзлэг”-ийг байгууллагын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, I, II, III дугаар шатны шалгалтыг өгч, “Бие бялдрын бэлтгэлжилтийн норматив, стандартын харьцуулалт” сэдэвт цахим сургалт, “Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ыг хэрэгжүүлэх, алба хаагчдыг сурган дадлагажуулах сургалтад чуулгын бие бүрэлдэхүүн хамрагдсан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Албан тушаал шатлан дэвшүүлэх багц сургалтад хамруулах шалгалт авах, нөөцөд дэвшүүлэн томилох” /Код/-909, 909.4.2-т заасны дагуу чуулгаас ахлах албан тушаалын нөөцөд 1, офицерын нөөцөд 3 алба хаагч бүртгүүлэхээр материалаа хүргүүлж, сургалтад бүрэн хамрагдаж, шалгалтаа өгч тэнцэн нөөцөд бүртгэгдсэн.

Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын баталсан төлөвлөгөө, хуваарийн дагуу Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын Эрүүл мэнд, сэтгэл зүйн хэсгийн ахлах сэтгэл зүйч, цагдаагийн хошууч Э.Бямбажаргалаар ахлуулсан сэтгэл зүйчдийн баг чуулгын алба хаагчдаас зан төлөвийн судалгааг авч, “Дадал” сэдэвт хичээл орж, 2 алба хаагч сэтгэл зүйчтэй ганцаарчлан уулзаж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сэтгэл зүйчдийн бэлтгэн ирүүлсэн 7 видео хичээлийг чуулгын цахим хаалттай бүлэгт байршуулан судлуулж, тэмдэглэл хөтлүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын даргаас ирүүлсэн 2023 оны 01 дүгээр сарын 11-ний 6/367 дугаартай албан бичгийн хүрээнд Хүч спорт хорооны сургалтын танхимд зохион байгуулсан “Амь тэнссэн үеийн амилуулах суурь тусламж” сэдэвт 1 цагийн лекц, 1 цагийн дадлагын сургалтад алба хаагчдыг хамруулав.

"Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын албаны бэлтгэлжилттэй холбоотой хууль, эрх зүйн мэдлэг, бие бялдрын түвшинг дээшлүүлэх хөтөлбөр" -ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хүч спорт хороотой хамтран долоо хоногт 1 удаа албаны бэлтгэлжилтийн сургалтад хамруулж хэвшив.

Чуулгын алба хаагчдын хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор алба хаагчдын чиг үүрэгтэй холбоотой, мэдвэл зохих 13 дүрэм, журам бүхий 45 ширхэг товхимол бэлтгэн хэвлэж алба хаагч тус бүрд тараан судлуулж мэдлэг, ойлголтыг бататгах цахим шалгалтыг зохион байгуулж дүгнэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны “Сургалт зохион байгуулах тухай” А/107 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд тус чуулгын алба хаагчдад “Хүний эрхийн тухай ойлголт, үндсэн зарчим, хязгаарлалт”, “Жагсаал цуглааны үед хүний эрхийг хангах”, “Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх” зэрэг сэдвээр давтан сургалтыг зохион байгууллаа.

Стратегийн команд штабын сургуулийн хүрээнд Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтэстэй хамтран “Гамшгийн үед ажиллах”, “Гал түймрээс урьдчилан сэргийлэх” сэдвүүдээр 2 цагийн сургалт хийж, орон даяар зохион байгуулсан гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуульд чуулгын алба хаагчид хамрагдав.

Чуулгын даргаас өгсөн үүргийн хэрэгжилтийг хангах чиглэлээр алба хаагчдын цэрэгжилч, жагсаалч байдлыг сайжруулах, цэргийн жагсаалын дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 14 хоногт 1 удаа жагсаалын бэлтгэл хийх хуваарь гарган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

"Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын албаны бэлтгэлжилттэй холбоотой хууль, эрх зүйн мэдлэг, бие бялдрын түвшинг дээшлүүлэх хөтөлбөр" -ийн хэрэгжилтийг хангах зорилгоор чуулгын эмэгтэй алба хаагчид удирдан алба хаагчдад өглөөний дасгал хийлгэх ажлыг эхлүүлсэн бөгөөд 10 удаагийн дасгал хөдөлгөөнд хамруулав.

Мөн чуулгын алба хаагчдын дунд 1 сарын эрчимтэй дасгал хөдөлгөөн, зөв хооллолтын хөтөлбөрийг бүжигчин, цагдаагийн ахлах ахлагч Г.Ууганбаярын дасгалжуулалт дор эхлүүлж, амжилттай явагдаж байна.

Дотоод Хэргийн Их сургуулийн бакалаврын 2023-2024 оны хичээлийн жилийн “Цагдаагийн ажил-Эрх зүй” эчнээ сургалтад 1 алба хаагч амжилттай хамрагдан төгсөж “Цагдаагийн ажил-Эрх зүйч” мэргэжил эзэмшсэн бөгөөд одоогийн байдлаар Дотоод Хэргийн Их сургуулийн эчнээ хөтөлбөрийн 1, 3 дугаар дамжаанд 1 алба хаагч суралцаж байна. Мөн цагдаа бэлтгэх дамжаанд 11 иргэн хамрагдан, Монгол Улсын Их сургуулийн докторын сургалтад 2 алба хаагч суралцаж байна.

**Соён гэгээрүүлэх чиглэлээр:** 2023 онд нийт 89 удаагийн соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 5437 алба хаагч, ажилтныг хамруулав. Үүнээс мэдээлэл сурталчилгааны 55 ажил, арга хэмжээнд давхардсан тоогоор 3363 алба хаагч, соёл хүмүүжлийн 34 ажилд 2074 алба хаагчийг хамруулан зохион байгуулав.

Удирдах дээд шатны байгууллагаас ирүүлсэн, шинээр баталсан болон нэмэлт, өөрчлөлт орсон хууль тогтоомж, төрийн болон байгууллагын бодлого чиглэл, үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийн талаар 91 удаа танилцуулж, “Сүлд цахим тайз” хаалттай фейсбүүк группт байршуулж, алба хаагчдыг мэдээллээр хангаж ажиллалаа.

Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Цагдаагийн албаны туг, Сүхбаатарын болон Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Дотоодын цэргийн байлдааны туганд

хүндэтгэл үзүүлэх, “Цагдаагийн тангараг” давтах ёслолын арга хэмжээнд чуулгын уран бүтээлчид 21 аймаг, алсын 3 дүүрэгт уран бүтээлийн тоглолт зохион байгуулсан.

Үндэсний нэгдмэл үнэт зүйлийг бэхжүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, соёлын салбарын ажилтнуудыг чадавхжуулах, соёл урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, соёлын үрийг тарих зорилгоор зохион байгуулж байгаа “Соёлын сэргэлт 2023” аяны арга хэмжээнд Сүхбаатар, Өвөрхангай аймгийн нийт 30 сумдад чуулгын уран бүтээлчид оролцсон.

Тус чуулгаас цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын дунд МУСГЗ, МЗЭ-ийн шагналт, яруу найрагч, цагдаагийн хурандаа Л.Гаваасүрэн агсны нэрэмжит “Монгол минь амгалан байна” дууны анхдугаар уралдааныг “Л.Гаваасүрэн сан”-тай хамтран хоёр үе шаттай зохион байгуулав.

Уралдааны нэгдүгээр үе шатыг албаараа бахархах, урлаг соёлын үр чадвар, танин мэдэхүйг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ахмадуудын дунд зохион байгуулж, нийт 45 анги, байгууллагын 100 гаруй алба хаагч оролцож, шилдгүүдийг шалгарууллаа.

Тулгар төрийн 2232, Их Монгол Улсын 817, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулга, Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга, Соёмбо чуулга, Сүлд чуулгын дунд Монголын үндэсний телевизээс бэлтгэсэн “Дөрвөн бэрх” монгол ёс заншил, уламжлалыг таниулан сурталчлах уралдаант цэнгээнт нэвтрүүлэгт цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас төлөөлөн Сүлд чуулгын уран бүтээлчид оролцож, тэргүүн байр эзлэсэн бөгөөд уг нэвтрүүлэг баяр наадмын өдрүүдээр үндэсний телевизийн эфирээр цацагдсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын алба хаагчдын хүүхдүүдэд соёл, гоо зүйн хүмүүжил төлөвшил олгох, урлагийн авьяасыг нээн илрүүлэх зорилгоор нийслэлийн хэмжээнд урлагийн тодорхой төрлөөр явуулж буй төлбөртэй 11, төлбөргүй 2 сургалтын төвүүдийн талаарх мэдээллийг судалж, жагсаалт гарган Соён гэгээрүүлэх албаны сургалтын хэлтэст 25/612 дугаартай албан бичгээр харьяа анги, нэгжийн алба хаагчдад мэдээллийг хүргүүлж, дэмжлэг үзүүлэх хүсэлтийг хүргүүлсэн.

Чуулгын “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-өөс сар бүр нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөн, тус зөвлөлөөс санаачлан “Албаны дүрэмт хувцасаараа гоёцгооё” уриан дор албандаа хүндэтгэлтэй хандаж, дүрэмт хувцасаа дүрмийн дагуу өмсөж хэрэглэх 1 сарын аяныг зохион байгуулсан.

“Хөгжөөнт захидал”, “Хөгжөөнт тэмцээн”, “Дархлаа дэмжье”, “Витаминжуулалтын аян”, “Буухиа тэмцээн”-ний үеэр “Хээрийн цай” уралдаан, “Үндэсний номын сангийн ховор номын үзмэр”-үүдийг танилцуулах, “Би Монгол бичгээрээ” уралдаан, “Занабазарын музей үзүүлэх арга хэмжээ”-г 400 гаруй алба хаагчийг хамруулан зохиосон байна.

2023 онд алба хаагчдын дунд сагсан бөмбөг, гар бөмбөг, боулинг, шагайн харваа, шагай шүүрэх, дартс, буухиа эмцээнүүдийг зохион байгуулж давхардсан тоогоор 360 алба хаагчийг хамруулав.

Цагдаагийн ерөнхий газрын харьяа алба, нэгжүүдийн дунд зохион байгуулсан гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд холимог баг, тамирчид амжилттай оролцож, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын дунд зохион байгуулсан түүхай өргөлтийн аварга шалгаруулах тэмцээн, дуатлон, дартс, гар бөмбөг, сагсан бөмбөг, таеквондо, жижиг, жүдо бөхийн тэмцээнд тус чуулгаас 47 алба хаагч оролцсон.

Чуулгын алба хаагчдад чиглэсэн ажлын хүрээнд “Яг түүн шиг” соён гэгээрүүлэх ажлыг хэсэг тус бүрийн дунд зохион байгуулав.

Түүнчлэн “Анд” хэвлэлийн газартай хамтран чуулгын байранд номын өдөрлөгийг зохион байгуулж, алба хаагчид 20%-ийн хөнгөлөлттэйгээр ном худалдан авах боломжийг бүрдүүлж ажиллав.

Би “Монгол бичгээрээ” уралдаан, “Бичиг үсгийн өв”, “Ховор үнэт ном”-ын музей, Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейг тус тус үзэж сонирхов.

Найм. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах,  
мэдээлэл, сурталчилгаа, зохион байгуулсан ажил,  
арга хэмжээний талаар

Чуулгын үйл ажиллагааг “Цагдаагийн СҮЛД чуулга” фэйсбүүк пэйж хаяг, [www.suld.police.gov.mn](http://www.suld.police.gov.mn) албан ёсны цахим хаягаар дамжуулан сурталчилж байгаа бөгөөд пэйж хуудсанд зочилсон хүний тоо 1.415.927 байна. Үүнээс:

- Идэвхтэй дагагчид 30.872 (тогтвортой хандалт өссөн үзүүлэлт) өсөлттэй байна.
- Шинээр дагасан хүний тоо 3.875
- Дагахаа больсон хүний тоо нэг жилийн хугацаанд 714
- Оруулсан цахим мэдээнд хариу үйлдэл үзүүлсэн 11.900
- Чуулгын фэйсбүүкээр аялсан 90.498
- Фэйсбүүк хуудаснаас мэдээлэл авсан нийт хүний тоо 1.633.085

“Сүлд цахим тайз” хаалттай хуудсанд ЗГ-ын тогтоол, ХЗДХ-ийн сайдын, ЦЕГ-ын даргын тушаал, ЦЕГ-ын холбогдох алба нэгжээс ирүүлсэн мэдээлэл сургалт зэрэг 167 удаагийн мэдээлэл

“Suld Ensemble” хуудсанд Урьдчилан сэргийлэх чиглэлээр: Постер 199, контент 132, видео бичлэг 58, фото мэдээ 198, ЦЕГ-аас гаргасан мэдээлэл 41 түгээж мөн 84 холбоос дамжуулсан байна.

“Сүлд Чуулга пэйж” хуудсанд алба хаагчдын 152 уран бүтээл, Фото мэдээ 122, Урьдчилан сэргийлэх контент 68, постер 133, мэндчилгээ 11, ажлын зар 16, сонгож оруулсан 1,234 фото мэдээ оруулж бусад 124 холбоос дамжуулсан байна. Цагдаагийн ерөнхий газрын Сүлд чуулга Бүгд Найрамдах Солонгос Улсын “Намвон хотын Үндэсний хөгжмийн хүрээлэнтэй цаашид хамтран соёлын өвийг сурталчлан таниулах, технологийн солилцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр “ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНД” хоёр талын удирдлага гарын үсэг зурах арга хэмжээг зохион байгуулсан.

#### Ес. Урлаг соёлын арга хэмжээний талаар

2023 оны эхний 11 сард цагдаа, дотоодын цэргийн анги байгууллага, алба хаагчид, ард иргэдэд давхардсан тоогоор 298 тоглолт, ёслолын арга хэмжээнд оролцсон байна.

- Хөгжмийн хэсэг нь 116 тоглолт
- Дууны хэсэг 128 тоглолт
- Бүжгийн хэсэг 54 тоглолтод оролцсон.

Олон улсын болон улсын уралдаан, фестивалиас тус чуулгын уран бүтээлчид нийт 8 удаа шагналт байранд шалгарсан амжилтыг гаргасан.

Монгол Улсын Соёлын Яамнаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Мөнгөн мод-2022” наадам нь соёлын өв, ном хэвлэл, дуу хөгжим, тайзны урлаг, дүрслэх урлаг, кино урлаг, нийтлэл нэвтрүүлэг, цахим бүтээл, архитектур, хувцас загвар, зар сурталчилгаа, дизайн гэсэн 12 төрлөөр шилдэг бүтээл шалгаруулдаг бол шилдэг уран бүтээлчдийг найруулагч, зураач, зохиолч, хөгжмийн зохиолч, продюсер, удирдаач, бүжиг дэглээч, жүжигчин, хөгжимчин, дуучин, бүжигчин, судлаач гэсэн 12 төрлөөр шалгаруулж, “Мөнгөн мод” цом, мөнгөн шагналаар урамшуулан шагнадаг. Энэ жил 14 дэх удаагийн 2023 оны шилдэг бүтээл, уран бүтээлч шалгаруулах “Мөнгөн Мод-2022” наадамд чуулгаас 7 төрөлд нэр дэвшүүлэх материалуудыг тус тус бэлтгэж цахим бүртгэлийг хугацаанд нь хийж хүлээлгэн өгсөн. Уг наадмаас тус чуулгын бүжгийн багш Ё.Дамчаабадгар нь Монголын анхны үндэсний балет Ж.Чулууны “Уран хас” балетын хөгжмийн зохиолыг нь албан ёсны зөвшөөрөл авч электрон хөгжмийн дуугаралт ашиглан шинэ дэглэлт, найруулгаар 2022 онд шинэчлэн тавьж уг бүтээлээрээ “Шилдэг бүжиг дэглээч” шагнал хүртсэн.

МУУГЗ, нэрт бүжиг дэглээч Д.Санжаасүрэн агсны нэрэмжит мэргэжлийн гоцлол болон цөөхүүл бүжигчидийн улсын анхдугаар уралдаанд оролцон бүжигчин цагдаагийн дэд ахлагч С. Хишигдүүрэн, Д.Долгормаа, Э.Халиун нар цөөхүүл төрөлд “ДЭД БАЙР”, бүжигчин Цагдаагийн дэслэгч А.Эрдэнэбаяр гоцлол төрөлд “ТУСГАЙ БАЙР” тус тус эзэлсэн.

Монголын шинэ үеийн дуу, хөгжмийг үндэслэгч Магсархурцын Дугаржавын мэндэлсний 130 жилийн ойд зориулан түүний зохиосон дууны уралдаанд тус чуулгын уртын дуучин, цагдаагийн ахлагч Л.Эрдэнэболд амжилттай оролцож “Тусгай” байр эзэлсэн.

БНСАУ-д зохион байгуулагдсан IDO world dance festival-д эмэгтэй насанд хүрэгчдийн этник төрөлд бүжиг дэглээч Ё. Дамчаабадгарын дэглэлт “Вангийн хатан” бүжгээр бүжигчин, цагдаагийн ахлах ахлагч Э. Жаргалмаа 4-р байрт шалгарсан.

Цагдаагийн Сүлд чуулгын нотны урын санг цахимжуулах ажлын хүрээнд 198 бүтээлийг нотны урын санд ангилан ялгалт хийж хөгжмийн бүтээлийн партитур, нотын хамт бүрдүүлэн 9 хавтасанд хийж жагсаалт гаргаж нотыг цаасаар болон цахим файлаар хадгалсан.

Үндэсний их баяр наадмын нээлт, “Тамгагүй төр” жүжиг, Налайх дүүрэгт 08 дугаар сарын 18-20-ны өдөр зохион байгуулагдсан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн нэрэмжит “Шилдэг офицер шалгаруулах тэмцээн”-ий нээлт, Монголын Цагдаагийн байгууллагад БНХАУ-ын Эрээн хотын нийгмийг аюулаас хамгаалах товчооны удирдлагууд айлчлал хийх үеийн тоглолт, Бүгд Найрамдах Солонгос улсын Үндэсний ардын аман зохиолын Гугак төвийн захирал ноён Ким Жун Хён-тэй хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурах үеийн хамтарсан тоглолт, Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийт, хүүхэд багачуудад сурталчлах, урлаг, соёл, спортын үралдаан, тэмцээн, арга хэмжээнүүдийг багтаасан “Хүүхэд таныг хамгаалья” өдөрлөгийн хөтөлбөр боловсруулж, төв цэнгэлдэх хүрээлэнд чуулгын уран бүтээлчдийн нэгдсэн тоглолт толилуулж, вертуаль музейгээр үйлчлэх, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын дунд зохион байгуулсан “Спортын наадам 2023” арга хэмжээний нээлт, хаалтын арга хэмжээг зохион байгуулах зэрэг томоохон арга хэмжээнүүдэд уран бүтээлээр үйлчилсэн.

#### Арав. Цагдаагийн музейн үйл ажиллагааны талаар

Цагдаагийн музейг шинэчлэн дэглэж, тохижуулахад шаардагдах эд зүйлсийн зардлыг шийдвэрлүүлэхээр 2022 онд ЦЕГ-ын СААА-нд 25/421 дугаартай албан бичиг хүргүүлэхэд “Төрийн хэмнэлтийн тухай хууль”, МУ-ын Засгийн газрын 2021 оны 43, 388 дугаар тогтоол, төсөв санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалж шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу өгсөн. Иймд өөрсдийн дотоод нөөц бололцоо, үзвэр, тоглолтын орлого зэргээс тохижилтын ажлыг үргэлжлүүлэн хийсэн. 2023 онд чуулгын даргаас өгсөн үүргийн дагуу музейг дэглэж дуусгахад шаардагдах зардлын тооцоо, судалгааг дахин гаргаж, 38.292.000 төгрөгийн төсвийн төслийг танилцуулсан. Тус чуулгаас ЦЕГ-ын СААА-нд 2023 оны 25/356 дугаартай албан бичгээр байгууллагын 2024 оны төсвийн төсөл, 2025-2026 оны төсвийн төсөөллөө хүргүүлсэн бөгөөд хавсралтаар музейн 3 дугаар давхарын танхимыг дэглэхэд шаардлагатай техник хэрэгсэл, эд зүйлсийн зардлын тооцоо, судалгааг гаргаж, 41.480.000 төгрөгийн төсвийн төслийг шийдвэрлүүлэхээр хүргүүлсэн.

2023 онд музейгээр алба хаагч 122, гэр бүлийн гишүүд 23, ахмад ажилтан 102, иргэд 88, хүүхэд залуучууд 165, нийт **500** хүн үйлчлүүлсэн.

Олон Улсын Музейн зөвлөлийн Монгол дахь Үндэсний хорооны 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн хүрээнд ICOM MONGOLIA, МУ-ын Соёлын яам, Чингис хаан Үндэсний музей, Чойжин ламын музейтэй хамтран 2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр Чингис хаан Үндэсний музейд Олон Улсын Музейн өдрийг тэмдэглэн өнгөрүүлээ. Тус чуулгаас “Музейн тогтвортой байдал ба сайн сайхны төлөө” сэдэвт ОУ-ын музейн өдрийн нээлтийн арга хэмжээг хөтлөн урлагийн хэсэгчилсэн тоглолтыг толилуулж, эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлэгт амжилттай оролцов.

Арван нэг. Санхүү, бүртгэл, хангамж,  
үйлчилгээний талаар

Санхүүгийн тайлангаар Сүлд чуулгын 2023 оны 12-р сарын 04-ны өдрийн байдлаар санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна.

Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2023 оны 09-р сарын 30-ны өдрийн байдлаар төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг ахлах нягтлан бодогч 2023 оны 09-р сарын 30-ны дотор бэлтгэн, 2023 оны 10 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Санхүү аж ахуйн албанд хүргүүлсэн.

Санхүүгийн тайлагналын хугацаа нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 2023 оны 11-р сарын 30-ээр дуусгавар болсон байна.

Тус байгууллагад 2023 оны 12-р сарын 04-ны өдрийн байдлаар улсын төсвөөс 1,402,9 сая төгрөг, өөрийн орлого 32,7 сая төгрөг нийт 1,435,7 сая төгрөгийн төсөв батлагдснаас гүйцэтгэлээр



улсын төсвийн санхүүжилт 1,368,7 сая төгрөг, өөрийн орлогоор 37,3 сая төгрөг төсөвт төвлөрүүлж бүгд 1,406.0 сая төгрөгийн эх үүсвэртэй ажиллаа.

Цагдаагийн байгууллага нь үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулахад бараа материалын зүйлсийг ашигладаг. Санхүүгийн тайланд тусгагдсан Бараа материал дансны эцсийн үлдэгдэл нь байгууллагын эзэмшилд бодитойгоор байгаа бүх бараа материалын зүйлсийг багтаасан.

Тус байгууллага нь бараа материалыг орлогод авах, зарцуулах буюу байгууллагын хэрэгцээнд тавьж олгохдоо бараа материалын байнгын системийг ашигласан болно. Байнгын системийн дагуу бараа материалын орлого ба зарлагын хөдөлгөөн өртгийг тухайн ажил гүйлгээ гарсан өдөр бүр тооцоолж бүртгэлийг хөтлөв.

Бараа материалын зарцуулалтыг тооцож бүртгэлд тусгахдаа эхэлж авсныг эхэлж зарлагдах аргыг хэрэглэсэн.

2023 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар цалин хөлсд 1,256,6, сая төгрөг, ажил олгогчоос 37,4 сая төгрөг, тогтмол зардалд /оснаауг, цахилгаан, цэвэр бохир ус/ 30,5 сая төгрөг, бичиг хэргийн материалд /бичгийн цаас, фото цаас, принтерийн хор г.м/ 3,1 сая төгрөг, аж ахуйн материалд /оо-ийн цаас, саван, вок, алчуур г.м/ 2,6 сая төгрөг, шуудан холбооны зардалд 1,2 мянга, чуулгын засвар үйлчилгээний зардал, гэрэл чийдэн, сангийн материал г.м/ 11,4 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд /сургалтын материал, гарын авлага, бэлэг дурсгал г.м/ 584 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж нийт 3 алба хаагчдад 500 мянга төгрөгийн зардалуудыг зохих журмын дагуу цохолтоор зарцуулагдаж мөн 04-р сарын дундаас [finance.gov.mn](http://finance.gov.mn)-ны цахим санхүүгийн программаар гүйлгээ хийгдэж эхэлсэн.

Улсын шилэн дансанд нийт 163 мэдээ мэдээлэл байршуулахаас 11 сарын байдлаар 137 мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд, хоцорч 4 мэдээ оруулсан.

➤ Гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгэдэг үйлчлэгч, слесарь, цахилгаанчин нарт сар бүр илүү цагаар ажилласан тооцоог гаргаж цалингийн нэмэгдлийн тогтмол олгуулж байна. Чуулгын байрны гадна цэвэрлэгээг тогтмол 7 хоногт 2 удаа хийлгэж ажиллаж байна.

➤ Чуулгын байрны дотор болон гадна цэвэрлэгээг үйлчлэгч нараар өдөр бүр ариутгалын бодис болон 70%-ийн уусмалтай спиртэн цэвэрлэгээг тогтмол хийлгүүлж цэвэр цэмцгэр байдлыг хангаж ажиллаж байна.

➤ Чуулгад гэрээгээр ажил үйлчилгээ гүйцэтгэдэг цахилгаанчин, слесарь, үйлчлэгч нарыг өдөр тутмын удирдлагаар хангаж хөдөлмөр аюулгүй ажиллагааны зааварчилгааг өдөр тутам өгч ажиллаж байна.

➤ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 429 дүгээр тушаалаар баталсан “Байгууллагын стандарт”-ын хэрэгжилтийг дагуу барилга байгууламжийн хувийн хэргийг хөтлөж баяжилтийг тухай бүрт хийж байна.

➤ Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд байрны телехяналтын камерын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахад хяналтын камерын засвар үйлчилгээг тухай бүрт нь тогтмол хийж ажиллаж байна.

➤ Чуулгын байранд хийгдэх засварын ажлын төсвийг тухай бүрт нь хийж чуулгын даргаар батлуулсан.

➤ Дээд байгууллага болон харьяа байгууллагаас ирсэн хугацаатай албан бичгийн хариуг тухай бүрт явуулж байсан.

➤ Байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд байрны телехяналтын камерын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахад хяналтын камерын засвар үйлчилгээг тухай бүрт нь тогтмол хийж ажиллаж байна.

Мөн байгууллагын [www.suld.police.gov.mn](http://www.suld.police.gov.mn) сайтад соёл урлаг санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, үйл ажиллагаа, тушаал, шийдвэр, видеоны мэдээний баяжуулалтыг тухай бүрт нь хийсэн. Мөн авилгатай тэмцэх газрын <https://iaac.mn/> сайт, улсын шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайтыг холбож ажилласан.

Арван хоёр. Алба хаагчдын нийгмийн асуудал,  
үүрэг гүйцэтгэх нөхцөл, боломжийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний талаар

Алба хаагчдыг албан үүргээ гүйцэтгэх нөхцлөөр хангах зорилготой тус чуулгын тоглолтын зааланд 2.000.000 төгрөгний тайзны гэрэлтүүлгийг байгууллагын урсгал зардлаас гаргаж хийсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас 2023 оны 05 дугаар сард Dell маркийн 1 ширхэг /иж бүрэн/ компьютерийг хүлээн авч бичиг хэргийн эрхлэгч, архивчид олгосон.

“Эрт илрүүлэг”-ийн үзлэг шинжилгээнд 64 алба хаагч, ажилтан хамрагдахаас 64 алба хаагч, ажилтан бүрэн хамрагдсан.

Тус чуулгын алба хаагч, ажилчдын “Дундын сан”-аас 2023 оны эхний 11 сарын байдлаар “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан 0-16 насны 73 хүүхдэд нийт 1.554.900 төгрөгний гарын бэлэг;

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 5 алба хаагч тус бүрт эргэлтийн 50.000 мянган төгрөг;

Хүнд хагалгаанд орсон 1 алба хаагчид 300.000 мянган төгрөг,

Ар гэрийн гачигдал гарсан 4 алба хаагчийн ар гэрт 2.000.000 сая төгрөгний хандив;

Шинэ хүүхэд мэндэлсэн 3 алба хаагчийн хүүхдэд тус бүрт 100.000 мянган төгрөгийг;

Төрийн одон медаль авсан 2 алба хаагчид тус бүр 100.000 мянган төгрөг

Олон улсын уралдаан тэмцээнд амжилттай оролцсон 4 алба хаагчид тус бүр 100.000 мянган төгрөг

Цэргийн алба хаасны, өндөр насны тэтгэвэрт гарсан нийт 5 алба хаагчид 1.110.000 төгрөгт бэлэг, дурсгалын зүйлс өгсөн байна.

Мөн “Төрийн албаны тухай хууль”-ийн 60 дугаар зүйлийн 60.1-д заасны дагуу цэргийн алба хаасны байнгын тэтгэвэрт гарсан 3 ахмад ажилтанд нэг удаагийн буцалтгүй тусламж олгож өгөх хүсэлтийг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба, Хүний нөөцийн хэлтэст хүргүүлж, 3 ахмад ажилтны 36 сарын тэтгэмжийг бүрэн олгуулсан.

Цагдаагийн ахлах ахлагч Д.Ихбаярт Цагдаагийн албаны тухай хуулийн 86.3-д “Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжинд заасны дагуу Засгийн газар дараах нөхөх олговор, тусламж олгоно”, 86.3.1-д “Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнээс шалтгаалан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөх олговор олгоно” заасан үндэслэл журмын дагуу ЦЕГ-ын даргад хүсэлт хүргүүлэн шийдвэрлүүлж, алба хаагчид 1 удаагийн нөхөх олговрыг олгуулсан.

Арван гурав. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам  
хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах  
болон эргүүл, хяналт шалгалтын талаар

2023 оны төрийн жинхэнэ алба хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас авлигын индексийг бууруулах чиглэлээр хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний хүрээнд Сүлд чуулгаас хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний салбар төлөвлөгөөг тус тус боловсруулан баталгаажуулсан.

Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”, “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын ЭБАТ-ийн ажил үүргийн дагуу 17 офицер алба хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг meduuleg.iaас.mn цахим хаягаар бүртгүүлж, баталгаажуулан нотломж /199 хуудас бүхий хадгаламжийн нэгж/-ийг ЦЕГ-ын АБХ-т хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан “Мэдүүлэг гаргагчдад зориулсан гарын авлага”-ыг тараан судлуулж, бие бүрэлдэхүүнд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Дэд дарга, Аюулгүй байдлын хэлтсээс ирүүлсэн үүрэг, ажлын чиглэлүүдийг тухай бүр танилцуулж иргэн хуулийн этгээдээс бэлэг, хандив, санхүүгийн туслалцаа авах асуудлаар хуульд заасан хориглолт, хязгаарлалтын хэмжээнд ажиллаж буй эсэхэд байнгын хяналт тавьж, алба хаагчдыг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Авлига, ашиг сонирхлоос ангид байх чиглэлээр офицер бүрэлдэхүүнээс 6, ахлагч бүрэлдэхүүнээс 5 заалт бүхий баталгааг тус тус авч ажилласан.

2023 оны эхний 11 сарын байдлаар ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл иргэд байгууллагаас ирээгүй болно.

Чуулгын 1 дүгээр давхарт байрлуулах “Авлигаас урьдчилан сэргийлэх мэдээллийн самбар”-т Авлигын эсрэг хууль, тогтоомж, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, авлигаас урьдчилан сэргийлэх

чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны материал, гарын авлага, төсвийн гүйцэтгэл, танилцуулга, худалдан авах ажиллагаа, шилэн дансны мэдээллийг шинэчлэн байршуулж ажилласан байна.

Арван дөрөв. Цаашид хэрэгжүүлэх ажил,  
арга хэмжээний талаар

1. Чуулгын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах ажил, арга хэмжээний саналыг боловсруулж ЦЕГ-т хүргүүлэх

2. Буриад улсад хийх тоглолтын хөтөлбөр гаргаж, шинэ уран бүтээл туурвих, уран бүтээлчдийг тоглолтын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах

3. Чуулгын уран бүтээлчдийг аттестачлах, мэргэжлийн үр чадварыг ахиулах чиглэлээр заралсан болзолт уралдааныг дүгнэх

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН СҮЛД ЧУУЛГА